



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/324

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Жаргалант хонгор хайрхан” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Сүү, цагаан идээ борлуулах цэгээс Ардчилсан намын байр хүртэлх шороотой талбайн тохижилтын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Ганзориг - Мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын Улсын байцаагч

Гишүүд:

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

З.Өмиртай - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Р.Цэдэнбал - Гавъяат барилгачин, Хөндлөнгийн орон тооны бус ажлын хэсгийн дарга

Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Д.Цогтхүү - Стандарт хэмжилзүйн хэлтсийн байцаагч

Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Батдорж

- Аймгийн архивын тасгийн дарга

Г.Саруул

- "Жаргалант хонгор хайрхан" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн дарга:

Д.Тогтохбаяр

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. "Жаргалант хонгор хайрхан" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Ганзориг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН